



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatrural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2021.09.21 № 34

Г Асуулт тавих тухай

2021 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Ашигт малтмал, газрын тосны газраас "АИ-92 шатахуун 21, дизель түлш 35 хоногийн нөөцтэй. Үнэ нэмэгдэх нөхцөл үүсээгүй" гэсэн мэдээллийг олон нийтэд өгсөн боловч өнөөдрийн байдлаар АИ-92, АИ-95 шатахууны хомсдол үүсч иргэдийг бухимдалд оруулаад байна.

Энэ онд улсын хэмжээнд нийт 616 мянга га талбайд тариалалт хийж, урьдчилсан дүнгээр 594,1 мянган тонн үр тариа, үүнээс 559,2 мянган тонн улаанбуудай, 198 мянган тонн төмс, 117 мянган тонн хүнсний ногоо, 64,3 мянган тонн тосны ургамал, 203,3 мянган тонн малын тэжээлийн ургамал тус тус хураан авах боломжтой гэжээ.

Өвөлжилтийн бэлтгэлийг хангаж, намрын ургац хураалт ид өрнөж байгаа энэ чухал цаг үед бензин, шатахууны хомсдол үүсэх нь улс орны нийгэм, эдийн засагт серег нөлөөтэй төдийгүй ард иргэдийн амьдралд хүндээр тусахаар байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т тус тус заасныг үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1.Үүсээд байгаа дээрх нөхцөл байдлын талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон хэвийн тогтвортой байдлыг хэзээ, хэрхэн хангах талаар;

2.Газар тариалангийн бүс нутаг /Сэлэнгэ аймаг/-т ургац хураалтын үед бензин, шатахууныг нөөцлөх, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

3.Цар тахлын энэ үед хүнсний болон гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэлт, стратегийн бараа бүтээгдэхүүний татан авалтад бензин, шатахууны хомсдоос үүсэх нөлөөллийг бууруулах чиглэлээр улсын хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын талаар;

4.Цаашид бензин, шатахууны хомсдол нь үнэд нөлөөлөх эсэх, үнийг тогтвожуулахаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэж буй талаар тодорхой хариулт ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн  
39.8 дахь хэсэгт заасан хугацаанд бэлтгэж ирүүлэхийг Танаас хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Д.ӨНӨРБОЛОР

2020000141

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн  
39.8 дахь хэсэгт заасан хугацаанд бэлтгэж ирүүлэхийг Танаас хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Д.ӨНӨРБОЛОР

2020000141